



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛААЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ
2019.07.26

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ЭХНИЙ VI САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

II. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум төгрөгийг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний 6 сарын байдлаар улсын төсөвт **1.3** их наяд төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **19.3** тэрбум төгрөг,
- Нүүрс **613.5** тэрбум төгрөг,
- Цайр **43.5** тэрбум төгрөг,
- Зэс **578.8** тэрбум төгрөг,
- Төмөр **12.6** тэрбум төгрөг,
- Жонш **15.8** тэрбум төгрөг,
- Бусад **30.7** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **308.4** тэрбум төгрөг буюу **30.7** хувиар өссөн байна. Үүнд:

- Нүүрс **211.1 (52.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **103.3 (21.7%)** тэрбум төгрөг,
- Төмөр **3.9 (44.9%)** тэрбум төгрөг,
- Жонш **7.5 (89.8%)** тэрбум төгрөг,

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Алт **8.8 (31.3%)** тэрбум төгрөг,
- Цайр **3.3 (7.0%)** тэрбум төгрөг.
- Бусад АМ **5.4 (14.9%)** тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018		2019		Өөрчлөлт			
	VI	I-VI	VI	I-VI	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	154.0	1,005.8	154.0	1,314.2	-0.0	0.0%	308.4	30.7%
Алт	7.3	28.1	3.5	19.3	-3.8	-52.2%	-8.8	-31.3%
Нүүрс	84.1	402.3	90.1	613.5	6.1	7.2%	211.1	52.5%
Цайр	3.4	46.8	2.2	43.5	-1.2	-35.3%	-3.3	-7.0%
Зэс	50.3	475.5	47.8	578.8	-2.5	-5.0%	103.3	21.7%
Төмөр	0.1	8.7	2.7	12.6	2.7	4415.6%	3.9	44.9%
Жонш	1.9	8.3	2.3	15.8	0.4	20.1%	7.5	89.8%
Бусад	7.0	36.1	5.4	30.7	-1.6	-22.4%	-5.4	-14.9%

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **25.1 сая тн** нүүрс, **681.6 мян.тн** зэсийн баяжмал, **5.5 тн** алт, **2.6 мян.тн** молибдений баяжмал, **66.0 мян.тн** хайлуур жоншны хүдэр, **27.1 мян.тн** хайлуур жоншны баяжмал, **3.8 сая тн** төмрийн хүдэр, **1.4 сая тн** төмрийн хүдрийн баяжмал, **43.3 мян.тн** цайрын баяжмал, **3.4 сая бар** газрын тос, **6.3 мян.тн** катодын зэс тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **1.7 сая тн** буюу **7.1** хувь, зэсийн баяжмал **31.4 мян.тн** буюу **4.8** хувь, төмрийн хүдэр **1.3 сая.тн** буюу **48.8** хувь, хайлуур жоншны хүдэр **7.7 мян.тн** буюу **13.2** хувь, цайрын баяжмал **3.7 мян.тн** буюу **9.3** хувиар тус тус өссөн байна.

Харин алт **1.4 тн** буюу **20.4** хувь, молибдены баяжмал **94.7 тн** буюу **3.6** хувь, төмрийн хүдрийн баяжмал **72.2 мян.тн** буюу **4.8** хувь, хайлуур жоншны баяжмал **5.4 мян.тн** буюу **16.6** хувь, газрын тос **16.4 мян.бар** буюу **0.5** хувь, катодын зэс **892.3 тн** буюу **12.4** хувиар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт			
			VI	I-VI	VI	I-VI	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	4,295.1	23,429.8	3,575.1	25,096.0	-720.0	-16.8%	1,666.2	7.1%
1.2	Газрын тос	мян.бар	539.7	3,377.7	575.6	3,361.3	35.9	6.7%	-16.4	-0.5%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	104.5	650.2	88.4	681.6	-16.1	-15.4%	31.4	4.8%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	521.9	2,666.7	402.8	2,572.0	-119.1	-22.8%	-94.7	-3.6%
1.5	Алт	кг	2,179.1	6,938.4	1,717.3	5,522.5	-461.8	-21.2%	-1,415.9	-20.4%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдэр	мян.тн	457.3	2,579.8	1,016.9	3,838.2	559.6	122.4%	1,258.4	48.8%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	310.1	1,516.1	225.1	1,443.9	-85.0	-27.4%	-72.2	-4.8%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	9.9	58.3	11.9	66.0	2.0	20.2%	7.7	13.2%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	9.9	32.5	13.5	27.1	3.6	36.4%	-5.4	-16.6%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	3.4	39.6	5.3	43.3	1.9	55.9%	3.7	9.3%
2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Катодын зэс, 99%	тн	1,149.2	7,181.2	884.4	6,288.9	-264.8	-23.0%	-892.3	-12.4%
2.2	Металл бэлдэц	тн	3,031.2	15,243.6	2,540.7	16,059.2	-490.5	-16.2%	815.6	5.4%
2.3	Металл цувимал	тн	3,784.3	16,577.5	3,072.4	16,429.4	-711.9	-18.8%	-148.1	-0.9%

Эх сурвалж: ҮСХ

II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	VI	I-VI	VI	I-VI	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,449.7	7,437.0	1,426.1	8,377.4	-23.6	-1.6%	940.5	12.6%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,025.7	5,323.1	1,009.8	6,044.9	-15.9	-1.6%	721.8	13.6%
Нүүрс олборлолт	369.8	1,944.3	406.8	2,627.1	37.0	10.0%	682.8	35.1%
Газрын тос олборлолт	86.7	524.4	82.3	502.5	-4.5	-5.1%	-21.9	-4.2%
Металлын хүдэр олборлолт	551.8	2,787.6	495.9	2,842.3	-55.9	-10.1%	54.7	2.0%
Бусад ашигт малтмал олборлолт	17.4	66.8	24.8	73.0	7.4	42.6%	6.2	9.3%
Боловсруулах аж үйлдвэр	356.3	1,568.9	336.7	1,725.9	-19.6	-5.5%	157.0	10.0%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны 6 сарын гүйцэтгэлээр **8.4** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **940.5 (12.6%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **6.0** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **721.8 (13.6%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **682.8 (35.1%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **54.7 (2.0%)** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.2** хувийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Гад-аад	Өөрчлөлт			
	VI	I-VI	VI	I-VI		(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,754.6	8,658.9	1,826.6	10,108.9	7,318.7	71.9	4.1%	1,450.0	16.7%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,173.2	5,998.8	1,304.7	7,071.9	6,233.9	131.4	11.2%	1,073.1	17.9%
Нүүрс олборлолт	358.2	2,084.9	468.0	2,708.1	2,463.4	109.7	30.6%	623.2	29.9%
Газрын тос олборлолт	87.1	514.2	77.2	473.2	473.2	-9.9	-11.3%	-41.0	-8.0%
Металлын хүдэр олборлолт	711.2	3,327.1	733.6	3,788.6	3,233.9	22.5	3.2%	461.4	13.9%
Бусад АМ олборлолт	16.8	72.5	25.9	102.1	63.4	9.1	54.5%	9.1	40.8%
Боловсруулах аж үйлдвэр	513.7	2,112.3	442.0	2,427.5	1,084.8	-71.7	-14.0%	315.2	14.9%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр жилд **10.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.5 (16.7%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **7.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.1 (17.9%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **623.2 (29.9%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **461.4 (13.9%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **7.3 (72.4%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **6.2 (61.7%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр **6.8** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **492.3 (7.8%)** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **1.0** тэрбум ам.доллараар эерэг гарсан байна.

3.1. ЭКСПОРТ

Экспорт **3.9** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **357.6 (10.0%)** сая ам.доллараар өссөн байна. Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.5** хувь буюу нийт экспортын **82.7** хувийг эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-V		2019 I-V		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн/сая \$	18.02	1,404.8	18.03	1,540.5	0.01	0.0%	135.7	9.7%
2	Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	733.72	1,014.0	749.15	1,062.4	15.43	2.1%	48.4	4.8%
3	Боловсруулаагүй нефть	сая бар/сая \$	3.30	212.4	3.18	179.7	-0.12	-3.7%	-32.8	-15.4%
4	Төмрийн хүдэр, баяжмал	сая тн/сая \$	3.37	156.1	4.12	251.8	0.74	22.0%	95.7	61.3%
5	Хайлуур жонш	мян.тн/сая \$	195.99	64.3	286.40	92.8	90.41	46.1%	28.5	44.3%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	61.63	108.0	72.36	107.1	10.72	17.4%	-0.8	-0.8%
7	Молибдений хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	2.81	22.5	2.81	24.8	-0.00	-0.1%	2.2	9.9%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	10.21	26.4	11.89	25.9	1.67	16.4%	-0.5	-1.9%
9	Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн/сая \$	25.09	0.3	39.13	0.6	14.04	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдын хүдэр, баяжмал	тн/сая \$	198.30	2.2	204.26	2.2	5.96	3.0%	-0.1	-2.6%
11	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн/сая \$	3.43	144.5	4.67	195.9	1.23	35.9%	51.4	35.6%

Эх сурвалж: ГЕГ

Чулуун нүүрс экспорт 2019 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **1.5** тэрбум ам.долларын **18.0** сая тн нүүрс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр **135.7** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **5.8** мян.тн-оор тус тус их байна. 2018 оны мөн үед **1** тн нүүрсний хилийн дундаж үнэ **77.9** ам.доллар байсан бол 2019 онд **85.4** ам.доллар болж өсчээ. Чулуун нүүрсний **97.9** % БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **749.1** мян.тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **15.4** мян.тн-оор их байгаа ба хилийн дундаж үнэ **1,382.0** ам.доллараас **1,418.2** ам.доллар болж **36.1** ам.доллараар өссөн байна. 2018 оны эхний VI сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **1.0** тэрбум ам.доллар байсан бол тайлант сард **1.1** тэрбум сая ам.доллар болсон.

Боловсруулаагүй нефтийн экспорт **3,177.3** мян.бар буюу **179.7** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **121.7** мян.бар-аар, үнийн дүнгээр **32.8** сая

ам.доллараар тус тус бага байна. 1 бар нефтийн хилийн дундаж үнэ **64.4** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **56.6** ам.доллар болж буурчээ.

Төмрийн хүдрийн экспорт **4,115.1** мян.тн буюу **251.8** сая ам.долларт хүрсэн байна. **2018** оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **741.9** мян.тн-оор, үнийн дүн нь **95.7** сая ам.доллараар тус тус өсчээ. 1 тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **61.2** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **14.9** ам.доллараар өссөн байна.

Цайрын баяжмал экспорт **2019** оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **72.4** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дунджаар **1,480.9** ам.доллараар экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **270.8** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **107.1** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **814.1** мянган ам.доллараар буурчээ.

Хайлуур жоншны экспорт **2019** оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **92.8** сая ам.долларын **286.4** мян.тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **90.4** мян.тн-оор, үнийн дүнгээр **28.5** сая ам.доллараар тус тус өссөн байна. Жоншны экспортын дундаж үнэ **324.1** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **4.1** ам.доллараар буурсан байна. Жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортлосон ба **33.5** хувь ОХУ-д, **66.1** хувь БНХАУ-д тус тус ногдож байна.

Молибдены баяжмалын экспорт **24.8** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **2.2** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний 1 тн-ны экспортын хилийн дундаж үнэ **8,010.5** ам.доллараас **8,811.1** ам.долларт хүрч, **800.6** ам.доллараар өсчээ. **2019** оны эхний хагас жилийн байдлаар **2,809.6** тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс **2.5** тн-оор бага байна. Молибдены баяжмалын **73.5** хувийг БНХАУ руу гаргасан байна.

Алтны экспорт **2019** оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **4,665.2** кг алт экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **1,233.3** кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ өнгөрсөн оны мөн үед **42,104.9** ам.доллар байсан бол энэ онд **41,998.0** ам.доллар болж **106.9** ам.доллараар багассан байна. Алтны экспорт үнийн дүнгээр **195.9** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **51.4** сая ам.доллараар өсчээ.

3.2. ИМПОРТ

Импорт **2.9** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **134.6 (4.9%)** сая ам.доллараар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **621.9** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **30.8** сая ам.доллараар буюу **5.2** хувиар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.1** хувийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. **2019** оны эхний 6 сард **523.1** сая ам.долларын **826.3** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **101.3** мян.тн-оор, үнийн дүнгээр **35.0** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **91.4** хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний **33.4** хувийг автобензин, **66.6** хувийг дизель түлшний импорт эзлэж байна.

Автобензины импорт 2019 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр **252.2** мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеийн дүнгээс **68.9** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **687.8** ам.доллар байсан бол **2019** оны эхний 6 сард **590.3** ам.доллар болж **14.2** хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт **503.2** мян.тн болж өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **111.2** мян.тн-оор өссөн байна. **2018** оны эхний 6 сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **645.7** ам.доллар байсан бол энэ онд **626.8** ам.долларт хүрч **18.9** ам.доллар буюу **2.9** хувиар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **62.3** сая ам.доллараар нэмэгджээ.